



НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ХОТЫН  
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2, 72 дугаар зүйлийн 72.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хагас жилийн хангамжийн материалыг тоолох, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч:	Г.Ганзориг	Ерөнхий инженер
Гишүүд:	Д.Түвшинжаргал	Ахлах диспетчер инженер
	Э.Мэндбаатар	Сүлжээний инженер
	Г.Билгүүн	Техник хангамжийн инженер
Нарийн бичгийн дарга:	Г.Ганзул	Ахлах диспетчер инженер

2. Тооллогыг 2018 оны 06 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулж, дүн мэдээг 2018 оны 06 дугаар сарын 28-ны дотор Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулахыг Тооллогын комисс /Г.Ганзоригт/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

2150300076